

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сэргэлэн	Дугаар	L303
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Шинэ-Идэр сум
Төрсөн газар	Шинэ-Идэр сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тэргүүн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Нүхтийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨШИ 025
Одоогийн сүм хийд	Дашпунцагчилин хийд	Сүм хийдийн дугаар	ХӨШИ 006
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймаг Шинэ-Идэр сум Нүхтийн хүрээ, Дашпунцагчилин хийд

Мөнхбат: За ингээд танаас асуух нэгдүгээр асуулт гэхээр Нүхтийн хүрээний хуучнаар Сай ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны буддын шашны соёлын томоохон төв шашин номын одоо том төвлөрсөн хүрээ хийд байжээ. Тэгэхээр энэ хүрээ анх байгулагдсан түүхийг эргэн дурсаж одоо дээд өвөг эцэг, одоо өндөр лам багш нараасаа сонссон нутгийн ахан дүүгээсээ сонссон хууч яриа зэргийг үндэслэн та хүрээнийхээ үүх түүхээс бид нарт сонирхуулна уу?

Сэргэлэн: За , за баярлалаа. Манай энэ Нүхтийн хүрээ бол одоо 1842 онд анх үүсгэн байгулагдсан гэж байгаа. Тэгэхээр анх эхлээд энэ урд талын юуны Мандахын хүрээ гэж байсан. Энэ Идэрийн голын хойд захад. Тэгээд Мандахын хүрээнд хурж байсан нутгийн хэдэн лам нар одоо тэндээсээ тасарч гараад тэгээд тэр Цэвэгдорж тайж гэдгийнх нь юугаар наашаа нутагтаа хүрч ирээд тэгээд анх одоо хоёр гурван газар, Цагаан усны хяр гэж энэ урд талын анх хураад, дараа нь энэ Цохиотод нэг хурсан байгаа юм. Дараа нь энэ агуйн хясааны шанаанд нэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хурсан.Тэгээд сүүлдээ тэр Гачин лам гэдэг Төвд ламаасаа газар асууж энэ Улаан өвөр гэдэг газар анх тэр 1842 онд тэр газар анх үүсгэн байгуулагдсан.

Мөнхбат: Тэгэхээр таны ярьж байгааг харахад бол бас санал нийлж байгаа зүйл бас гарч ирж байна л даа.Манай судалгааны баг Хөвсгөл аймгийн Жаргал, Галт сумаар судалгаа хийгээд явж байхад Жаргал, Галт сум бол хуучин Далай чойнхор вангийн хошууны Ар хамжлага баг.Тэгэхээр Ар хамжлага багийн нутаг дэвсгэр бол Жаргал сум, Галт төмөрбулаг тэр чигээрээ ордог, одоогийн.Тэгэхээр одоогийн Хөвсгөл аймгийн Галт сумын нутагт байгаа Мандахын ам гэдэг газар байгаа Мандахын хурлын тухай тухайн нутгийн өндөр настан Шагдарсүрэн гэдэг хүнтэй бид нар ярилдцлага хийсэн.Тэгэхэд Шагдарсүрэн гуай ярьж байсан л даа. Мандахын хүрэнээс Нүхтийн хүрээ салсан.Тэр бол одоо Мандахын хүрээний жинхэнэ нэр нь Дүүрэгчхайн хүрээ гээд байгаа юм.Тэгээд салсныг нь бол одоо тэр хүн ярьсан, тийм нутгийн ард түмний гарсан ярианаас үзэхэд хэдэн лам нар маань таарахаа байгаад ингээд салж нүүсэн юм аа.Тэндээс нүүх тууриа гарсан юм аа гэж нэг сонирхолтой юм ярьж байсан.За ямар ч байсан ингээд энэ хоёр ярианаас үзэхэд бол Нүхтийн хүрээ маань ингээд Мандахын хүрэнээс туурга тусгаарлаж гарсан нь бол ойлгомжтой юм байна.Тэгэхээр Нүхтийн хүрээний шажин номынх нь нэр томъёоны тал дээр бас хоёулаа одоо санал солилцоё. Тэгэхээр одоо ингээд Дашпунцагчилэн хийд гээд тэгж байна, тийм ээ. Тэгэхээр Ренчин академичийн гаргасан жагсаалтанд анх Нүхтийн хүрээг ямар даржаалин билээ, галсандаржаалин гэж нэрээр ингэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр энэ одоо ямар утга учиртай юм бол оо , энийг та тайлбарлаж хэлж өгнө үү?

Сэргэлэн:За ер нь бол зүгээр энэ хийдийн жинхэнэ хайрласан нэр нь бол Дашпунцагчилэн гэж. Гэхдээ энэ сүүлийн нэг андуу ташаарсан явдал бол Галсандаржаалин гэж нэр бичсэн байгаа.Тэгэхээр энэ болохоор энэ хойд уулыгаа Галсандаржаалин гэж нэрлэсэн байдаг.Тэгэхээр энэ нэрээр одоо бас ингээд зарим газар тэмдэглэгдсэн байна л даа.Тэгээд тэр Төвдийн Гачин лам гэдгийг залж авчраад долоо хоног ном энэ тэр тавиулж үйл ажиллагаа явуулсан гэж байгаа. Тэгэхээр тэр лам ирээд энэ хойд Улаан өвөр гэдэг уулыг галсандаржаалин гэж нэрлэ ээ, энэ их Дарь эхийн шинжтэй хэлбэртэй уул байна аа гэж нэр хайрласан.Энэ урд талдаа энэ Хужирт толгой гээд энүүхэн энд суварга босгочихсон байгаа. Энэ толгойд бол Эрдэнэ толгой гэж хайрла аа гээд хайрлаад тэгээд тэгж нэр хайрласан. Тэр Галсандаржаалин гэдэг хойд уулын нэр л дээ.

Мөнхбат: За Төвдөөс Гачин ламыг удаа дараа залж уриж, авчирч шүтэж байсан ийм үзэгдэл бол Халхын шарын шашны түүхэнд зөвхөн Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны сүм хийдүүдэд одоо илүү их түгээмэл байсан үзэгдэл юм шиг байгаа юм, тийм ээ.Өөр одоо зүүн тийшээ байдаг юм уу, төв Халхын сумуудад Гачин ламыг бол авчирч байсан тийм тохиолдол байдаггүй юм байна. Тэгэхлээр бол ер нь сонсож байгаагүй юм байна, тийм ээ. Тэгэхээр энэ дээр бол бас их сонирхолтой юм байна.За ингээд танаас асуух дараачийн асуулт гэвэл, Нүхтийн хүрээ маань энэ үүсэн хөгжсөн тоо баримтыг нь харахад үндсэндээ нэг хоёр зуу шахуу жилийн түүхтэй ийм хүрээ хийдийн газар болох нь тодорхой байна.Тэгэхээр одоо энэ хүрээ яг шажин номынхоо ид мандан бадралын үед бурхан номын үйл ажиллагааг хэвийн явуулж байсан тэр цаг үеийн дор ямар ямар одоо

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хурал ном хурдаг байсан, шашны ямар ямар зан үйлийг одоо үйлддэг байсан, энэ утгаараа нутгийн сүсэгтэн олонд одоо хэрхэн үйлчилдэг байсан талаар та одоо тодруулахгүй юу?

Сэргэлэн: За манай хүрээ хийд бол одоо жилийн том дүйчэнгүүдэд бол одоо тухайн хурлуудад хурдаг номоо одоо хурдаг.Тэгээд өвөл одоо, өвлийн эхэн сарын зулын хорин таванд магтаал ерөөл хурдаг байсан.Бурхан багшийнхаа, ринбүүчийнхээ чог номыг хурдаг.Өвөл бол хангал магтаал гэж бас хурдаг байсан байгаа юм.Цагаан сарын урд талын одоо хорин хоёрноос, өвлийн адаг сарын хорин хоёрноос хуучдын хурал гээд арван хангалаа өдөрт нэг нэгээр нь хорин найман хүртэл хурж байсан. Тэгээд хорин есөндөө бас чойжингоо хураад сор залдаг.Сор залаад тэгээд Нүхтийн хүрээ чинь энэ хойшоогоо гудамлачихсан одоо ийм халзан гудамтай. Тэгээд сороо бол хорин есний орой залдаг.Тэгээд нутгийн ард түмэн бол сордоо мөргөнө гээд, сордоо шургана гээд маш олуулаа цуглаад.Тэгээд сороо бол ингээд дамнуур модон дээр залаад хоёр лам явдаг. Доогуур нь одоо нутгийн ард түмэн сордоо шургаад, тэгээд хойд тал дээрээ залдаг байсан юм гэнэ лээ. Манай энэ хойд талынхаа, хүрээнийхээ ард бас овоотой байдаг.Тэгээд овооныхоо хойд руу л залдаг байсан юм шиг байгаа юм, хөгшчүүлийн ярианаас сонсоход.Тэгээд л лам нь одоо сороо залаад л , тэгээд л том гал жигтэйхэн гал унтраачихсан.Тэгээд л одоолам нар олон лам нар эгнээд , олон цамтай.Тэгээд их сүрхий сайхан, тэгээд сороо залаад л буу буудаад л , цахиур буу.Тэгээд л туг муг барьсан хүн ингэж зөрж гүйгээд л.Их сүрхий сайхан үйл явдал болдог байсан юм билээ.Тэгээд битүүнийхээ орой бол битүүндээ цэдэр лхамаа хурна.Оройжин суугаад л өглөө болтол лхамаа яамлаад л .Өглөө үүрээр л тэгээд тангарагаа, цэдэр лхамынхаа тангарагаа өргөөд. Тэгээд өглөөгүүр лам нар нь гэртээ ирчихээд буцаж ирээд тэгээд мандлаа өргөөд тэгээд золгож байсан юм шиг байгаа юм.Тэгээд шиний нэгэн, манай энд бол одоо шинийн хоёрноосоо бол чоймборлын хурал тийм ээ.Тэр хурал шинийн хоёрноос болж байсан юм шиг байгаа юм аа.Тэгээд одоо ч гэсэн манайхан яг ёс жаягаар нь хурж байгаа.Тэгээд их маналыг бол өдөр болгон хурдаг.Үдээс өмнө гурван манжаар хурдаг.Үдээс хойш гурван манжны хуралтай.Тэгээд магтаалын манж, дарь эхийн манж, ерөөлийн манж гээд ийм чойнгорол жүнго гэж арван таван хоног ийм ном хурж байсан.Тэгээд л одоо дүйчэнгүүд, мөн хурал одоо зуны эхэн сарын арван таван, зуны адаг сарын шинийн дөрвөн, чойнхор гурвын дүйч, намрын адаг сарын хорин хоёрон, зулын хорин таван иймэрхүү хурлууд бас хурж байсан байгаа юм аа.Тэгээд зун долоон сар, долоон сарын сүүлчээр бол майдраа хурдаг байсан юм байна лээ.Тэгээд одоо тиймэрхүү хурлуудыг хурж байсан байна.

Мөнхбат: За тэгэхээр таниас дараачийн асуух асуулт юу гэхлээр хорьдугаар зууны эхэн үеэр, ялангуяа хорьдугаар зууны гучаад оны үеэс тухайн үеийн төр засаг бурхны шашныг элдвээр шахан хавчиж, энэ шашнаас төрсөн олон арван мяндагтан, эрдэмтэн чадалтай, шашны их ухаанд нэвтэрсэн том лам нарыг хавчин хяхаж, сүм хийдийг нурааж шатааж галдсан ийм эмгэнэлтэй түүх монголын түүхэнд бичигдэж үлдсэн байдаг.Тэгэхээр тэр цагийн үед, 1936, 1937, 1938 оны үед Нүхтийн хүрээний түүхэн хувь заяа бас одоо энэ эмгэнэлтэй үеийг давтсан, тойроогүй биш дайрсан байж таарна.Тэгэхээр энэ талаар нутгийн хөгшчүүл, ахмадууд сүсэгтэн олон хэрэхэн одоо ярьж дурсаж байсан бол оо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэргэлэн: Аа энэ гучин долоон оны үед, гучаад оны үед бол тэр том толгой лам нараас нь эхлээд л устгаж байсан юм шиг байгаа юм. Тэр том лам нарыг нь бариад энэ сэртэнгийн үзүүр гэж хойд талын үзүүрийн, үзүүрээр одоо тэр морьтой явган улсуудыг тууж аваад, тэр сэртэнгийн гуу гэж хойд талдаа нэг гуу байдаг юм. Тэр гуу дээр аваачаад л одоо хороосон гэж ярьдаг юм байна лээ, хөгшчүүл хууччуулын ярихыг одоо сонсоход. Тэгээд л тэр юу яагаад л, сүм хийдийг нь нураагаад, шатаагаад л тэр залуу лам нараар нь одоо буулгуулж барьж шатааж байсан. Бид нар одоо тэр дуганы юуг нь авч байсан гээд л бас хөгшчүүл ярьж байхыг сонссон юм байна. Тэгж л байсан юм шиг байгаа юм.

Мөнхбат: За тэгэхээр хоёулаа одоо, дараачийн асуулт нь гэхлээр 1990-ээд онд монгол оронд явагдсан хүний эрх, эрх чөлөө шашин шүтэх, эс шүтэх ёсыг эрхэмлэсэн, бурхан шашнаа дээдлэн шүтсэн тэр сайн цагийн эхлэл дээр хоёр зуугаад жилийн түүхтэй Нүхтийн хүрээ эргэж сэргэж мандаж, бурхны шашин жинхэнэ утгаараа сүсэгтэн олондоо үйлчилж эхэлсэн тэр шинэ цагийн эхлэл дээр Нүхтийн хүрээг сэргээж байсан тэр үеийн дурсамжаа хуваалцахгүй юу? Та одоо тэр үед бараг магадгүй шинээр суурин дээрээ боссон энэ хийдийн бараг анхны шавь нарын нэг байсан гэж сонссон.

Сэргэлэн: Аа мянга есөн зуун ерэн онд, цагаан морин жил намар, намрын адаг сарын хорин хоёронд л анх хурал хурж эхэлсэн дээ. Тэгээд манай одоо хоёулаа багш байсан, Данжаа лодов цоноймид, Чойжил гээд. Хоёулаа өндөр настай лам байсан, нэг нь ер гаруй настай, нэг нь наяд гаруй настай. Тэгээд хориод шахуу, арван хэдэн ийм хөгшчүүл цуглаж байж одоо энэ хурал эхэлсэн юм байгаа юм. Тэгээд тэр үед бол одоо сүсэгтний холбоо гэж байгуулагдаж байсан. Тэр үед ч нөгөө нэг компани гээд болчихсон байлаа, нэгдэл. Тэр үед сүсэгтний холбоо гээд бас нэг хэдэн улсууд нийлж, тав зургаан улсууд. Тэгээд хойноос тэр зөвшөөрлийг нь аваад, иргэдийн хурлаас ингэж эхлэлсэн юм байна лээ. Тэгээд одоо манай тэр хоёр багш байсан, унзад Ламжав гуай гээд лам байлаа. Тэгээд л энэ одоо арван хэдэн хөгшчүүл нийлээд л одоо энэ хурлыг эхлүүлсэн юм даа. Би тэгэхэд чинь одоо 1990 онд анх л багшдаа шавь орж, ном үзэж эхлэхэд нь сууж байсан ууган шавийн нэг дээ. За тэр цагаас хойш одоо даруй арван тав, зургаан жил өнгөрчээ. Нэгэн арван тав, зургаан жилийн өмнө үйл ажиллагаагаа шинэ тутам эхэлж байсан энэ Дашпунцагчилэн хийд хүнээр бол одоо эрийн цээнд хүрсэн. Ер нь бол одоо бид нарын явсан, өнгөрсөн хугацаанд явсан Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Галт, Жаргал сумын төв дээрх хийд хурал номын газруудтай харьцуулахад бол тохижилтын хувьд, дэг жаягийн хувьд, бэхжилтийн хувьд ч гэдэг юм уу, тийм ээ. Лам хуварга одоогийн цагаар бол боловсон хүчний хувьд харьцангуй илүү хэмжээнд хүрсэн юм уу даа гэсэн ийм сэтгэгдлийг төрүүлж байна. Тэгэхээр энэ хийдийнхээ одоо цаашдын зорилго, зорилт тийм ээ, таны ойрын одоо бодож санаж явдаг, лам хуваргуудынхаа ийм саналыг та одоо товч хэлж өгнө үү?

Сэргэлэн: За манайх ч инь одоо ерэн оноос хойш бас өдийг хүртэл тасралтгүй хурал хурж ирсэн. Би бол одоо энд ерэн оноос эхлээд ерэн таван он хүртэл хуралд хурж байгаад, ерэн таван онд хотод одоо монголын бурхан шашны төв Гандантэгчилэн хийдийн Дашчоймбол дацанд шавилан суугаад, хоёр мянга гурван он хүртэл одоо тэнд сууж хорчин домын дамжаа барьсан. За тэндээсээ гурван онд, Энэтхэг улсын өмнөд энэтхэгийн Гомон дацанд, цаньд чойрын ном үздэг тэр дацанд бас хоёр жил хагас сууж ном үзэж байгаад 2006 онд ирсэн. 2006

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

онд ирээд 2006 оны хавраас одоо энэ хүрээ хийдээ өргөтгөөд сүм дуганаа өргөтгөөд цаашдын одоо бас тэр лам нарын сургалт хурал хүйг өргөжүүлэх үүднээс ихэд том шинээр дуган барьж байгаа.Тэгээд эндээсээ энэ дуганаа бариад , энэ намар ашиглалтанд оруулаад тэгээд цаашдаа бас одоо байнгын боловсон хүчинг бэлтгээд, хурал номоо одоо байгаа хэмжээнд хураад хуримтлуулаад, жилийн одоо хурах ёстой хурал, ёс жаяг тэр бүгдийг нь гүйцэлдүүлээд, тэгээд одоо ард түмнийхээ хүсэл зорилго, сүсэг бишрэлийг хангаад ингээд цааш нь одоо оршин тогтнох тал дээр л тийм зорилготой байна даа.